



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН
ТӨВИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2025/31/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор Н.Хулансүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: khulansurenn@audit.gov.mn

Дархан-Уул аймаг

2025 он

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	16
3.5.3 Нэмэлт төсөв	16
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	17
3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	17
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	19
5.2 Албан шаардлага	19
5.3 Зөвлөмж	19
6. . АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СЗСҮТ	Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ХБХХТ	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025-02-25 № 48

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд албан хаагчдад 990.5 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл, 2,023.6 мянган төгрөгийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, 992.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал илүү олгосон, унаа хоолны нөхөх төлбөрийг хөдөлмөрийн дотоод журамд тодорхой заагаагүйгээс 3 удаа нэмэгдүүлэн өөрчилж, 20,491.6 мянган төгрөгөөр хэтрүүлсэн зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын 1.3, 8.2, 8.4 дэх хэсэгтэй нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны А-1/1189 дугаар албан бичгээр “Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв” УТҮГ-аас үнэ төлбөргүй шилжүүлсэн 1,113,811.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг биет болон биет бус хөрөнгөөр бүртгэж, толилуулсан байна.

4525020121

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 164 дүгээр тогтоолоор Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв УТҮГ-ын харьяанд 6 аймагт “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв”-ийг байгуулах шийдвэр гарч, тус байгууллага 2024 оны 02 сарын 14-ний өдрөөс иргэдэд үйлчилж эхэлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвөөс 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 24 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг 91.2 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	<u>124,011,875.40</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	-	124,011,875.40
351	Түүхий эд материал	-	884,265.00
35110	Тусгай зориулалттай материал	-	884,265.00
354	Хангамжийн материал	-	123,127,610.40
35420	Аж ахуйн материал	-	4,007,000.00
35440	Түлш, шатах тослох материал	-	1,275,742.90
35470	Бусад хангамжийн материал	-	117,844,867.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	<u>1,338,954,500.37</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	1,338,954,500.37
392	Биет хөрөнгө	-	1,157,331,083.77
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	82,482,420.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(859,191.88)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	-	1,036,978,360.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	(142,002,784.77)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-	188,133,708.58
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	(21,901,779.06)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	15,130,800.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(630,450.00)
393	Биет бус хөрөнгө	-	181,623,416.60
39301	Програм хангамж	-	2,783,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,159,583.40)
39303	Бусад биет бус хөрөнгө	-	180,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	=	<u>1,462,966,375.77</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	<u>1,462,966,375.77</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	-	1,462,966,375.77
512	Хуримтлагдсан үр дүн	-	1,462,966,375.77
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,462,966,375.77
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	=	<u>1,462,966,375.77</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	2,451,292,624.46
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,484,059,924.46
120	Нийтлэг татварын бус орлого	-	1,484,059,924.46
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,484,059,924.46
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	1,484,059,924.46
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	967,232,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	964,265,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	964,265,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	2,967,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,967,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	988,326,248.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	988,326,248.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	841,734,027.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	582,591,289.06
210101	Үндсэн цалин	-	344,327,121.09
210102	Нэмэгдэл	-	124,921,167.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	62,014,000.00
210104	Урамшуулал	-	51,329,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	74,509,819.02
210201	Тэтгэврийн даатгал	-	51,803,186.71
210202	Тэтгэмжийн даатгал	-	5,883,040.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	3,146,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	2,922,688.04
210205	Эрүүл мэндийн даатгал	-	10,754,903.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	27,881,788.92
210301	Гэрэл, цахилгаан	-	8,327,255.76
210302	Түлш, халаалт	-	17,043,884.96
210303	Цэвэр, бохир ус	-	2,510,648.20
2104	Хангамж, бараа материалын зардал	-	23,201,967.60
210401	Бичиг хэрэг	-	5,947,400.00
210402	Тээвэр, шатахуун	-	3,040,657.10
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	3,766,298.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	2,286,240.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	8,161,372.50
2105	Нормативт зардал	-	20,335,068.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	16,759,368.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	3,575,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	12,719,620.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	2,089,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	893,250.00
210604	Урсгал засвар	-	9,737,270.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	43,249,291.24
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	38,963,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	75,141.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	33,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	32,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	930,050.24

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	3,215,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	57,245,184.09
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	6,528,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	50,716,384.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	146,592,220.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	3,720,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	3,720,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	142,872,220.76
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	142,872,220.76
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-	<u>1,462,966,375.77</u>
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-	<u>1,462,966,375.77</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	-	967,232,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	967,232,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	964,265,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	964,265,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	2,967,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,967,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	-	941,231,350.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	941,231,350.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	794,639,129.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	582,591,289.06
210101	Үндсэн цалин	-	344,327,121.09
210102	Нэмэгдэл	-	124,921,167.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	62,014,000.00
210104	Урамшуулал	-	51,329,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	74,509,819.02
210201	Тэтгэврийн даатгал	-	51,803,186.71
210202	Тэтгэмжийн даатгал	-	5,883,040.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	3,146,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	2,922,688.04
210205	Эрүүл мэндийн даатгал	-	10,754,903.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	27,881,788.92
210301	Гэрэл, цахилгаан	-	8,327,255.76
210302	Түлш, халаалт	-	17,043,884.96
210303	Цэвэр, бохир ус	-	2,510,648.20
2104	Хангамж, бараа материалын зардал	-	20,185,188.00
210401	Бичиг хэрэг	-	2,937,400.00
210402	Тээвэр, шатахуун	-	4,316,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	3,766,298.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	2,286,240.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	6,878,850.00
2105	Нормативт зардал	-	20,335,068.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	16,759,368.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	3,575,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	14,553,385.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	2,089,100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	1,372,265.00
210604	Урсгал засвар	-	11,092,020.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	47,935,291.24
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	43,463,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	75,141.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	33,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	32,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	930,050.24
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	3,401,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	6,647,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	6,647,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	146,592,220.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	3,720,000.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	3,720,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	142,872,220.76
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	142,872,220.76
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	<u>26,001,350.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	26,001,350.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	26,001,350.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	26,001,350.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	26,001,350.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(26,001,350.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
D01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,462,966,375.77	-	1,462,966,375.77
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,462,966,375.77	-	1,462,966,375.77

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	964,265,700.00	821,393,479.24	(142,872,220.76)	85.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	964,265,700.00	821,393,479.24	(142,872,220.76)	85.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	960,430,900.00	817,673,479.24	(142,757,420.76)	85.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	650,023,900.00	582,591,289.06	(67,432,610.94)	89.6
210101	Үндсэн цалин	364,032,500.00	344,327,121.09	(19,705,378.91)	94.6
210102	Нэмэгдэл	186,767,900.00	124,921,167.97	(61,846,732.03)	66.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	49,442,400.00	62,014,000.00	12,571,600.00	125.4
210104	Урамшуулал	49,781,100.00	51,329,000.00	1,547,900.00	103.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,651,600.00	74,509,819.02	(4,141,780.98)	94.7
210201	Тэтгэврийн даатгал	53,483,100.00	51,803,186.71	(1,679,913.29)	96.9
210202	Тэтгэмжийн даатгал	6,292,100.00	5,883,040.48	(409,059.52)	93.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,146,000.00	3,146,000.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,146,100.00	2,922,688.04	(223,411.96)	92.9
210205	Эрүүл мэндийн даатгал	12,584,300.00	10,754,903.79	(1,829,396.21)	85.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	85,801,000.00	27,881,788.92	(57,919,211.08)	32.5
210301	Гэрэл, цахилгаан	22,800,000.00	8,327,255.76	(14,472,744.24)	36.5
210302	Түлш, халаалт	40,299,500.00	17,043,884.96	(23,255,615.04)	42.3
210303	Цэвэр, бохир ус	22,701,500.00	2,510,648.20	(20,190,851.80)	11.1
2104	Хангамж, бараа материалын зардал	20,702,400.00	20,185,188.00	(517,212.00)	97.5
210401	Бичиг хэрэг	2,962,000.00	2,937,400.00	(24,600.00)	99.2
210402	Тээвэр, шатахуун	4,316,400.00	4,316,400.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,967,800.00	3,766,298.00	(201,502.00)	94.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,570,200.00	2,286,240.00	(283,960.00)	89.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,886,000.00	6,878,850.00	(7,150.00)	99.9
2105	Нормативт зардал	33,653,500.00	28,032,618.00	(5,620,882.00)	83.3
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,077,800.00	24,456,918.00	(5,620,882.00)	81.3
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,575,700.00	3,575,700.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,251,700.00	32,857,185.00	(1,394,515.00)	95.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,447,600.00	20,392,900.00	(54,700.00)	99.7
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,703,100.00	1,372,265.00	(1,330,835.00)	50.8
210604	Урсгал засвар	11,101,000.00	11,092,020.00	(8,980.00)	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,422,800.00	47,935,291.24	(5,487,508.76)	89.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,500,000.00	43,463,200.00	(36,800.00)	99.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,525,200.00	0.00	(2,525,200.00)	-

210803	Даатгалын үйлчилгээ	140,400.00	75,141.00	(65,259.00)	53.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	95,600.00	33,500.00	(62,100.00)	35.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	32,400.00	32,400.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,625,200.00	930,050.24	(1,695,149.76)	35.4
210807	Газрын төлбөр	981,000.00	0.00	(981,000.00)	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,523,000.00	3,401,000.00	(122,000.00)	96.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,924,000.00	3,680,300.00	(243,700.00)	93.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,924,000.00	3,680,300.00	(243,700.00)	93.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,834,800.00	3,720,000.00	(114,800.00)	97.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,834,800.00	3,720,000.00	(114,800.00)	97.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,834,800.00	3,720,000.00	(114,800.00)	97.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	964,265,700.00	821,393,479.24	(142,872,220.76)	85.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	964,265,700.00	821,393,479.24	(142,872,220.76)	85.2
131001	Улсын төсвөөс санхүүжих	964,265,700.00	821,393,479.24	(142,872,220.76)	85.2
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	25.00	23.00	(2.00)	92.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	19.00	17.00	(2.00)	89.5
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25.00	23.00	(2.00)	92.0
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМ)	4.00	4.00	-	100.0
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	6.00	6.00	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	15.00	13.00	(2.00)	86.7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,967,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,967,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,967,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,967,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,967,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,967,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,967,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,967,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгчид болон тэдний гэр бүлийг хөгжүүлэх, дасгалжуулах, дадлагажуулах түүнчлэн лавлагаа төвүүдтэй холбох, кейс менежментийн тусламжтай хянах, арга зүй, мэдээллээр хангах нийгмийн төв байх чиг үүрэгтэй, Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв УТҮГ-ын харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь “Үйлчлүүлэгчийн эрхийг хүндлэн дээдэлж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст сэргээн засалтын цогц үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх, бие даан хөгжих чадварыг эзэмшүүлэх замаар амьдралын чанарыг сайжруулахад оршино” гэсэн эрхэм зорилгын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрэгчдэд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлэх, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, төрөл бүрийн сургалтад хамруулах, гэр бүл, асран хамгаалагч, олон нийтэд зориулсан сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах, протез, ортопедийн туслах хэрэгслийг тохируулах, ашиглах, зөвлөгөө өгөх зорилгыг дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Татварын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон холбогдох дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн даргын 2023 оны А/61 дугаар тушаалаар баталж, мөрдөж эхэлсэн байна. Тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,462,966.4 мянган төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	-	124,011.8	124,011.8
Үндсэн хөрөнгө	-	1,338,954.5	1,338,954.5
Нийт хөрөнгө	-	1,462,966.4	1,462,966.4
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	-	1,462,966.4	1,462,966.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	-	1,462,966.4	1,462,966.4

Тайлант онд мөнгөн хөрөнгийн болон авлагын данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны хувьд Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв болон бусад байгууллагаас нийт 120,390.4 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, төсвийн хөрөнгөөр 60,592.2 мянган төгрөгийн материал бэлтгэж, үйл ажиллагаанд 56,970.7 мянган төгрөгийн материал зарцуулснаар оны эцэст 124,011.8 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнасан байна. Үүнд аж ахуйн материал болон бусад хангамжийн материал нийт бараа материалын 98.3 хувийг эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,338,954.5 мянган төгрөгөөр илэрхийлэгдсэн нь ТӨБЗГ-ын 2024 оны А-1/1189 дугаар албан бичгийг үндэслэн Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвөөс 1,113,811.6 мянган төгрөг, аймгийн Засаг даргын 2024 оны 01-А/491, 01-А/450 дугаар захирамжуудаар 97,136.6 мянган төгрөг, бусад байгууллагаас 268,558.7 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч, улсын төсвийн хөрөнгөөр 26,001.4 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 166,553.8 мянган төгрөгийн элэгдлийн зардал бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант үеийн 1,463.0 мянган төгрөгийн үр дүнгээр илэрхийлэгджээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвөөс 2024 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 2023 оны 07 дугаар сард 1,020,632.3 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг улсын төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Дээд шатны төсвийн захирагч төсвийн саналыг нийт 92,226.3 мянган төгрөгөөр бууруулж, 928,406.0 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь бараа, үйлчилгээний зардлыг

93,011.1 мянган төгрөгөөр бууруулж, урсгал шилжүүлгийг нийт 784.8 мянган төгрөгөөр нэмсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд батлагдсан төсвийг 35,859.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож, 964,265.7 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2024 онд цалин хөлс, бараа материал, эд хогшил, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж, урсгал шилжүүлгийг 43,359.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нормативт зардлыг 7,500.0 мянган төгрөгөөр бууруулсантай холбоотой байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэх 964,265.7 мянган төгрөгийн эх үүсвэрийг улсын төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс авсан 964,265.7 мянган төгрөгийн санхүүжилтээс 821,393.5 мянган төгрөгийг зарцуулж, санхүүжилтээс үлдсэн 142,872.2 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Энэ нь тайлант онд орон тоо дутуу ажилласнаар цалин хөлс болон НДШ-ийн зардлыг 71,574.4 мянган төгрөгөөр, ашиглалтын зардлыг уурын зуухтай аймгийн жишгээр төлөвлөсөн тул 57,919.2 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал, нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж зардал, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлгийн зардлыг 13,378.8 мянган төгрөг тус тус зарцуулаагүйтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувиар/
1	72206-Дархан-Уул аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв	964,265.7	821,393.5	(142,872.2)	85.2
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	960,430.9	817,673.5	(142,757.4)	85.1
1.2	80802-Ажил олгогчоор олгох тэтгэмж	3,834.8	3,720.0	(114.8)	97.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэгдсэн судалгааны дүнгээр тус төв нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/159 тушаалаар 30 орон тоо баталснаас, 2024 оны төсөвт 25 орон тооны цалин хөлсний зардлын төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 23 албан хаагч ажилласан байна.

Тус байгууллага нь шинээр байгуулагдсан, ахмад настан байхгүй тул ахмадын сан байгуулаагүй байна.

Нэгдсэн судалгааны дүнгээр тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна. Тайлант онд бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний зардалд 43,500.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 3,924.0 мянган төгрөг төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулжээ.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн засаг даргын тамгын газрын даргын 2024 оны 02-А/209 дугаар тушаалаар “Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан “Бэрх биш ээлтэй Дархан” өдөрлөгийг 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулахтай холбоотой зардлын 2,967.0 мянган төгрөгийг 100 хувь зарцуулж тайлагнасан байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газрын аудитор Н.Хулансүрэн гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 16 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 928,406.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 9,284.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д заасны дагуу хангамж, бараа материалын зардлыг 517.2 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 26 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих мэдээллээс 198 мэдээлэл бүхий 4,243,093.5 мянган төгрөгийн мэдээллийг хоцроосон, 1,219,309.4 мянган төгрөгийн мэдээллийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8-д заасны дагуу дээрх мэдээллийг нөхөж байршуулахаар, мөн алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2024 онд шинээр байгуулагдсан болно.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Түлш халаалтын зардлыг уурын зуухтай аймгийн жишгээр төлөвлөснөөс тус зардлыг 23,255.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан байна. Иймд зардлыг бодитой төлөвлөхөд анхаарах нь зүйтэй байна..

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нийт 268,848.4 мянган төгрөгийн 3 алдааг¹ аудитын явцад залруулав. Үүнд:

1. Мөнгөн гүйлгээ, санхүүгийн үр дүнгийн тайланд 142,872.2 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлэг, 4,110.0 мянган төгрөгийн цалин, нэмэгдэл, урамшууллын зардал, 3,040.7 мянган төгрөгийн тээвэр шатахууны зардал зэргийг өөр зардлын ангилалд бүртгэсэн нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 8 дугаар зүйлийн 8.4, 15 дугаар зүйлийн 15.1, 15.2-д заасантай нийцэхгүй байгаа тул холбогдох зардлын ангилалд тусгаж залруулав.

2. Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2024 оны А/39 дугаартай "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" жагсаалтаар ирсэн хөрөнгийг бүртгэлд тусгахдаа үлдэгдэл өртгөөр орлогод авсан нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

5.1.4, 8 дугаар зүйлийн 8.4, 15 дугаар зүйлийн 15.1, 15.2-т заасантай нийцэхгүй байгаа тул үндсэн хөрөнгийн тайланд 115,837.4 мянган төгрөгийг залруулав.

3. Үндсэн хөрөнгийг анхны өртгөөр орлогод авснаас элэгдлийн зардлыг 2,988.1 мянган төгрөгөөр дутуу тооцсон нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 8 дугаар зүйлийн 8.4, 15 дугаар зүйлийн 15.1, 15.2-д заасантай нийцээгүй тул хуримтлагдсан элэгдлийг залруулав.

Мөн аудитаар илэрсэн 24,497.7 мянган төгрөгийн зөрчил²-д 4,006.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 20,491.6 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

Тайлант онд 6 албан хаагчид 990.5 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл, 7 албан хаагчид 2,023.6 мянган төгрөгийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, сахилгын шийтгэлтэй 2 албан хаагчид 992.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг тус тус илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8 дахь хэсэгт заасантай нийцээгүй тул төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

Тайлант онд албан хаагчдад олгох хоол, унааны нөхөх төлбөрийг хөдөлмөрийн дотоод журамд тодорхой дүнгээр батлаагүйгээс байгууллагын удирдлагын 3 удаагийн тушаалаар 10.0 мянган төгрөгөөс 34.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталснаас төсөв 20,491.6 мянган төгрөгөөр хэтэрч, батлагдсан төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын 1.3, 8.2, 8.4 дэх хэсэгт заасантай нийцээгүй тул албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Тайлангийн 4.4.1-т дурдсан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. . АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Мөнгөн гүйлгээний тайлан ба санхүүгийн үр дүнгийн тайланд татан төвлөрүүлэлтийн 142,872.2 мянган төгрөгийг дансны ангилал зөрүүлж, үндсэн цалин, нэмэгдэл, урамшуулал зардлыг 4,110.0 мянган төгрөгөөр зардлын ангилал зөрүүлж, тэвэр шатахууны зардлын 3,040.7 мянган төгрөгийг түлш, халаалтын зардалд бүртгэсэн зөрчил илэрлээ.	1	150,022.9	-	-	1	150,022.9	1	150,022.9	-	-	-	-
Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2024 оны А/39 дугаартай "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" жагсаалтаар үндсэн хөрөнгийг программд бүртгэж авахдаа хөрөнгийн анхны өртгийг оруулахдаа хөрөнгийн үлдэх өртгөөр оруулан 115,837.4 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.	1	115,837.4	1	115,837.4	-	-	1	115,837.4	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход анхны өртгийг буруу оруулснаар 2,988.1 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг дутуу байгуулсан зөрчил илэрлээ.	1	2,988.1	-	-	1	2,988.1	1	2,988.1	-	-	-	-
Дүн	3	268,848.4	1	115,837.4	2	153,011.0	3	268,848.4	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд 6 албан хаагчид 990.5 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл, 7 албан хаагчид 2,023.6 мянган төгрөгийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, сахилгын шийтгэлтэй 2 албан хаагчид 992.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг тус тус илүү олгосон байна.	1	4,006.1	1	4,006.1	-	-	-	-	-	-	-	-
Тайлант онд албан хаагчдад олгох хоол, унааны нөхөх төлбөрийг хөдөлмөрийн дотоод журамд тодорхой дүнгээр батлаагүйгээс байгууллагын удирдлагын 3 удаагийн тушаалаар 10.0 мянган төгрөгөөс 34.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталснаас төсөв 20,491.6	1	20,491.6	-	-	1	20,491.6	-	-	-	-	-	-

